ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ДОРНОГОВЬ АЙМГИЙН НЭГДСЭН ДҮН

/хураангуй/

АГУУЛГА

1. ХҮН АМ.....4
2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА.....5
3. ШАШИН.....6
4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ.....6
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН.....7
6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ.....8
7. ӨРХ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....9
8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ.....10
9. ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ.....12
10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....13
11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД.....16
12. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2000,2010, 2020 ОН
ХҮСНЭГТ 2. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН
ХҮСНЭГТ 3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, сумаар, нийт хүн амд эзлэх хувиар,2020 ОН
ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН
ХҮСНЭГТ 5. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН
ХҮСНЭГТ 6. ГАДААДАД АМЬДАРЧ БАЙГАА ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТОО,УЛСААР, 2020 ОН
ХҮСНЭГТ 7. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2019, 2020 ОН

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР
ЗУРАГ 2. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО
ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ ХУВИАР 2010, 2020 ОН
ЗУРАГ 4. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ
ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН
ЗУРАГ 6. 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМ
ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН
ЗУРАГ 8. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС
ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН
ЗУРАГ 10. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН
ЗУРАГ 11. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН

ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН

ЗУРАГ 13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН

ЗУРАГ 14. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН, ЯВСАН ЗОРИЛГО, ХУВИАР, 2010, 2020 ОН

ЗУРАГ 15. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН

ЗУРАГ 16. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН

1. ХҮН АМ

Дорноговь аймгийн хүн ам 71014, өрхийн тоо 20115 болсныг тоолж гаргалаа. Хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилд дунджаар 2.1 хувиар өссөн байна. Жилийн дундаж өсөлт өмнөх тооллогоос 0.7 пунктээр нэмэгдсэн нь хүн амын цэвэр өсөлт сүүлчийн арван жилд их байсантай холбоотой юм.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



ЗУРАГ 2. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО



Дорноговь аймгийн хүн ам насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа ба 0-14 насны хүүхэд 32.0 хувь, 15-64 насны хүн ам 64.3 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 3.7 хувь эзэлж байна. Хүн амын хүйсийн харьцаа 100.6 болж, өмнөх тооллогын үеэс 1.0 пунктээр буурчээ. Мөн хүйсийн харьцаа нь 30, түүнээс дээш насны бүлэгт буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байдагтай холбоотой.

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хуваж байгаа голч нас 27.2 болсон нь хүн амын тэн хагас нь 27.2-оос доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна. Нийт хүн амын 2.0 хувь нь буюу 1.4 мянган хүн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байна. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгч хүн амын тоо 55.5 байна.

Хүн ам зүйн ачаалал 2020 онд 2010 оноос 6.6 пунктээр өссөн. Хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх юм.

2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн. Тооллогын үр дүнгийн танилцуулгад 100-аас цөөн хүн амтай бүлгийг “Бусад” гэж нэгтгэсэн болно.

ХҮСНЭГТ 1. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2000,2010, 2020 ОН

Үндэс угсаа	2000		2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	**50 474**	**100.0**	**57 611**	**100.0**	**69 638**	**100.0**
Халх	49 564	98.2	56 206	97.6	67 208	96.5
Дарьганга	287	0.6	357	0.6	950	1.4
Казах	85	0.2	90	0.2	112	0.2
Буриад	133	0.3	0.0	0.0	238	0.3
Баяд	39	0.1	100	0.2	148	0.2
Дөрвөд	147	0.3	174	0.3	354	0.5
Торгууд	0	0.0	58	0.1	60	0.1
Дархад	0	0.0	26	0.0	56	0.1
Бусад	219	0.4	600	1.0	512	0.7

3. ШАШИН

Арван тав түүнээс дээш насны хүн амын 49.6 хувь нь шашин шүтдэг, 50.4 хувь нь шашин шүтдэггүй гэж тоологдлоо. Шашин шүтдэг хүмүүсийн 89.1 хувь нь буддын шашинтан байна.

Хүн амын дийлэнх нь буддын шашинтан боловч насны бүлгээр авч үзэхэд 15-19 насны өсвөр үеийнхний хувьд христ, бөөгийн шашинтан олонх байна.

ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ ХУВИАР 2010, 2020 ОН



4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Дорноговь аймгийн хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 40.9 хувь өмнөд бүсэд, 39.1 хувь төвийн бүсэд, 20.0 хувь нь хойд бүсэд оршин сууж байна.

ЗУРАГ 4. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ



ХҮСНЭГТ 2. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Сумдыг бүсчилсэн байдал	Бүсэд багтах сумдын нэр	Хүн ам			2020 2010	Дүнд эзлэх хувь		
		2000	2010	2020		2000	2010	2020
БҮГД		**50 575**	**57 930**	**69 859**	**120.6**	**100.0**	**100.0**	**100.0**
Хойд бүс	Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Өргөн, Алтанширээ	10 393	10 288	14 000	136.1	20.5	17.8	20.0
Төвийн бүс	Сайхандулаан, Сайншанд	23 146	24 697	27 278	110.5	45.8	42.6	39.1
Өмнөд бүс	Эрдэнэ, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Замын-Үүд, Мандах	17 036	22 945	28 581	124.6	33.7	39.6	40.9

Дорноговь аймгийн хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 0.46 хүн ногдож байсан бол 2010 онд 0.53 хүн, 2020 онд 0.64 болж өссөн байна. Замын-Үүд сумын хүн амын нягтрал 41.5 хувиар, Өргөн, Сайншанд сумын 25.5-25.7 хувиар тус тус өсжээ.

5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 20.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 19.9 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН



Сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөнд аймаг нийслэлийн хоорондох шилжилт хөдөлгөөнд 7.9 хувийг эзэлж 2010 оны тооллогоос 5.9 пунктээр буурсан байна.

Сүүлийн жилүүдэд нийт шилжилт хөдөлгөөний 49.7 хувийг Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эзэлж байгаа нь хот руу чиглэсэн урсгал эрчимжсэн байна.

6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш насны хүн амын 94.6 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Харин 15, түүнээс дээш насны хүн амын 98.2 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

Боловсролын түвшин өмнө жилүүдээс харьцангуй өссөн ба бичиг үсэг мэддэггүй хүн амын түвшин буурчээ. Арав ба түүнээс дээш насны хүн амын дүнд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь багассан байна. Харин дийлэнх нь буюу 25.7 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

ЗУРАГ 6. 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМ



Дээд боловсролтой хүн амын түвшин өмнөх тооллогоос өссөн үзүүлэлттэй гарч байна. Арав ба түүнээс дээш насны Дорноговь аймгийн харьяат суурин хүн амын 27.7 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой болсон нь 2010 оны үр дүнтэй харьцуулахад 8.5 пунктээр өссөн байна.

7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн тоо 2010 оноос 19.1 хувиар өссөний дотор хотын өрх 27.4 хувиар, хөдөөний өрх 14.3 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд 20.1 мянган өрх тоологдсоноос 61.7 хувь ам бүлээрээ байгаа өрх, 20.2 хувь нийлмэл ам бүлтэй, 16.8 хувь нь ганц бие өрх, 1.3 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН

Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.5 болсон нь 2010 оны аймгийн дундаж тооноос 0.2-оор илүү байна.

Өрхийн ам бүлийн тоогоор 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь 3.0 пунктээр, 5-6 ам бүлтэй өрхийнх 3.4 пунктээр, 7-оос дээш ам бүлтэй өрхийнх 2.2 пунктээр өмнөх тооллогын дүнгээс тус тус нэмэгдсэн бол 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь 8.5 пунктээр буурсан байна.

Хүн амын гэрлэлтийн байдалд огт гэрлээгүй хүний тоо өмнөх тооллогоос 2.5 пункт, бэлбэсэн хүний тоо 0.6 пунктээр нэмэгдэж, харин гэр бүлтэй хүний тоо 3.1 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 8. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС



Анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэй 27.3, эмэгтэй 24.9 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад 2 насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор 2-3 насны байгаа нь сүүлийн хориг жилд өөрчлөгдсөнгүй.

8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Дорноговь хэмжээнд 2.7 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 3.8 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1.6 мянга буюу 59.0 хувь нь эрэгтэй, 1.1 мянга буюу 41.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



ХҮСНЭГТ 3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, сумаар, нийт хүн амд эзлэх хувиар, 2020 ОН

Сум	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	**2 560**	**1 500**	**1 060**	**2 654**	**1 567**	**1 087**
Айраг	245	148	97	174	111	63
Алтанширээ	44	29	15	61	40	21
Даланжаргалан	102	61	41	95	59	36
Дэлгэрэх	59	32	27	77	49	28
Иххэт	191	128	63	164	93	71
Мандах	85	49	36	70	47	23
Өргөн	80	51	29	104	69	35
Сайхандулаан	72	46	26	50	32	18
Улаанбадрах	72	45	27	55	41	14
Хатанбулаг	132	71	61	104	58	46
Хөвсгөл	71	38	33	59	32	27
Эрдэнэ	98	53	45	130	75	55
Сайншанд	951	544	407	1 044	591	453
Замын-Үүд	358	205	153	467	270	197

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх тооллогоос 141-ээр буюу 16.7 хувиар өссөн байна.

Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өмнөх тооллогоос 47-оор 2.7 хувиар буурсан нь аж ахуй нэгжийн аюулгүй ажиллагаа болон үйлдвэрийн осол гэмтэл, хүнд нөхцөлийн аюулгүй ажиллагаа сайжирсан байж болох юм.

Иймд төрөлхийн бэрхшээл их байгаа шалтгааныг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл, хорт нөлөө зэрэг олон талаас нь нарийвчлан судлах шаардлага байна гэж харж байна.

Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл 2010 оны тооллогоос ярианы бэрхшээл 48.1 хувиар, сонсголын бэрхшээл 27.6 хувиар, харааны бэрхшээл 20.4 хувь, хөдөлгөөний бэрхшээл 11.7 хувиар, тус тус буурч, сэтгэцийн бэрхшээл 20.7 хувиар өссөн байна. Нийт бэрхшээлийн дийлэнх буюу 29.5 хувийг бусад (Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав), 28.1 хувийг хөдөлгөөний бэрхшээл эзэлж байгаа бол хамгийн бага буюу 3.0 хувийг ярианы бэрхшээл эзэлж байна.

Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь ой тогтоол/ санах байгаа бол 35-54 насныхны хувьд алхах, харин 55 түүнээс насныхны хувьд алхах,сонсгол, хараа, өөртөө анхаарал тавих хүндрэлүүд байгаа нь нас ахих тусам эдгээр хүндрэл зонхилж байгааг харж болохоор байна.

ЗУРАГ 10. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

9. ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор зургаа ба түүнээс насны нийт суурин хүн амын 87.2 хувь гар утас хэрэглэж байгаа бол 61.9 хувь интернэт хэрэглэгчид байна. Зургаа ба түүнээс дээш насны гар утас, интернэт хэрэглэгчдийн дүнд эзлэх хувь 2010 оноос харьцангуй өссөн ба гар утас хэрэглэгчид 12.9 пунктээр, интернэт хэрэглэгчид 38.5 пунктээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 11. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон байнга интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН



9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 36.4 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 0.3 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам 0.3 хувиар өсжээ. Ерөнхийд нь үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн тооллогын үеийнхтэй ижил түвшинд байна. Ажиллах хүчний оролцоо эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээс 12.4 пунктээр их байна.

Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 7.0 пунктээр нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын хувийн жин 2.4 пунктээр буурч, ажилгүй иргэд 2.2 хувийг эзэлж байна. 60, түүнээс дээш насны хүн амын 21.3 хувь ажиллах хүчинд хамрагдаж байна. Энэ нь хөдөөгийн ажилгүй иргэдийн тоо хотынхоос 27.5 пунктээр өндөр байгаа нь хөдөөгийн эрэгтэйчүүдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байна.

ЗУРАГ 13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН

Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 75.5 хувь байгаа нь хотынхоос 9.2 пунктээр илүү байна.

Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амын 61.4 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хотод 58.1 хувь байна. Хотын эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт хөдөөгийнх 9.3 пунктээр өндөр байна.

ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүчний оролцооны түвшин	63.6	69.9	57.5	60.4	66.3	55.0	69.0	75.5	61.9
Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь	36.4	30.1	42.5	39.6	33.7	45.0	31.0	24.5	38.1

Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 3.5 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 11.4 пунктээр буурчээ. Ажилгүйдлийн түвшин хотод өндөр, хөдөөд 0.6 пунктээр бага байна.

ХҮСНЭГТ 5. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	Ажилгүй иргэд	Ажилгүйдлийн түвшин	Ажилгүй иргэд	Ажилгүйдлийн түвшин	Ажилгүй иргэд	Ажилгүйдлийн түвшин
БҮГД	**1 054**	**3.5**	**672**	**3.7**	**382**	**3.1**
Эрэгтэй	534	3.2	328	3.5	206	2.9
Эмэгтэй	520	3.8	344	4.0	176	3.3

Ажилгүй иргэдийн дотор 25-49 насны 768 иргэн байгаа нь хамгийн их буюу нийт ажилгүй хүний 72.9 хувийг эзэлж байна. Харин эрэгтэйчүүд нийт ажилгүй иргэдийн 50.7 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 17282 байгаа нь өмнөх тооллогоос 17.4 хувиар өсчээ. Нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 36.5 хувь нь сургуульд сурдаг хүний тоо, 26.6 хувь нь тэтгэвэрт хамрагдаж буй хүний тоо, 13.1 хувь нь тохирох ажил олдохгүй байгаа хүний тоо тус тус эзэлж байна. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүй, бусад иргэд нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 0.5-9.1 хувийг эзэлж байна.

11.ГАДААД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 1376 иргэн тоологдож 2010 оноос 2 дахин өсчээ.

ХҮСНЭГТ 6. ГАДААДАД АМЬДАРЧ БАЙГАА ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТОО,УЛСААР, 2020 ОН

Одоо амьдарч байгаа улс	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	**100.0**	**100.0**	**100.0**
Солонгос /Өмнөд/	48.8	53.6	44.0
Хятад	15.3	13.4	17.2
Япон	5.3	6.0	4.6
Австрали	4.5	4.1	4.9
Америк	4.1	2.8	5.4
Бусад	22.0	20.1	23.9

Гадаадад оршин суугаа иргэдийн 39.8% хувиараа ажиллах, 33.4%, суралцах зорилгоор, 6.3% хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 3.9% суурьших зорилгоор, 4.9% гэр бүлийн шалтгаанаар оршин суухаар, 0.7% албан томилолтоор, бусад зорилгоор 11.0 хувь нь гадаадад оршин сууж байна.

ЗУРАГ 14. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН, ЯВСАН ЗОРИЛГО, ХУВИАР, 2010, 2020 ОН



12.СУУЦНЫ НӨХЦӨЛ

Дорноговь аймагт Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр ний 20.1 мянган өрх 18.8 мянган сууцанд амьдарч байна. Амьдарч буй өрхийн тоо, хүн байнга амьдардаг сууцны тооны харьцаа хотод ойролцоо байхад, хөдөөд өрхийн тоо нь илүү байна. Энэ нь хөдөөд нэг сууцанд олон өрхүүд хамт амьдардаг байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 7. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2019, 2020 ОН

	Хүн байнга амьдардаг сууц			Өрхийн тоо		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	**18 836**	**12 907**	**5 929**	**20 115**	**12 142**	**7 973**
Гэр	5 805	2 028	3 777	8 273	3 080	5 193
Байшин	13 031	10 879	2 152	11 583	8 896	2 687
Бусад сууц	-	-	-	259	166	93

Тайлбар: Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав.

Нийт өрхийн 41.1 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц болох гэр, 57.6 хувь нь байшинд, 1.3 хувь нь бусад сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 4.3 пунктээр, бусад сууцанд амьдардаг өрхийн хувь 0.1 пунктээр тус тус буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 4.4 пунктээр нэмэгджээ.

ЗУРАГ 15 ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Байшин орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 10.5 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 18.8 мянган сууц тоологдсон байна. Харин хүн байнга амьдардаггүй илүү гэр, зуслангийн байшин зэрэг 4.3 мянган сууц тоологджээ.

ЗУРАГ 16. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 55.5 хувь нь гэр сууц, 39.7 хувь нь сууцны тусдаа байшин, 3.0 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 1.4 хувь нь бие даасан тохилог сууц, 0.4 хувь нь нийтийн байр тоологдсон.

Нийтийн зориулалттай 311 орон сууцны байшинд 8686 сууц тоологдсон байна.